

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

СЭТГҮҮЛ ЗҮЙ, ОЛОН НИЙТИЙН
ХАРИЛЦААНЫ ТЭНХИМ

“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ”-ИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРАЛД ЗОРИУЛСАН ИЛТГЭЛ

ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДҮРИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД
УЧИРЧ БАЙГАА ТУЛГАМДСАН АСУУДАЛД

Гүйцэтгэсэн: Э.Хишигжаргал /МУИС, ШУС, ОУСЗ-3-р курсийн оюутан/

Удирдсан: Г.Мэндхүү /МУИС, ШУС, СЗОНХТэнхмийн багш, доктор/

УЛААНБААТАР

2014

ХУРААНГУЙ

Монголын шар сонингууд дахь эмэгтэйчүүдийн, тэр тусмаа улс төрч эмэгтэйчүүдийн дүр төрхийн хандлагыг судалгаагаар тодорхойлж, сэтгүүлчдийн нийгэмд үзүүлэх нөлөөгөө ухамсарлах талаарх асуудлыг тусгав. Хэвлэлийн эрх чөлөө ардчилсан нийгмээр тэтгэгддэг, харин ардчилал эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоогоор тэтгэгддэг гэдэг саналыг дэвшүүлсэн.

ТҮЛХҮҮР ҮГ

Жендэрийн стереотип, имиж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр имиж бүрдүүлэх, ёс зүйн үүргээ ухамсарлах

ОРШИЛ

Ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь бидний эрх мөн ч бусдын эрхээр хязгаарлагддаг гэдэг ардчиллын зарчмыг байнга санавал зохистой. Нийгмийн санал бодлыг төлөвшүүлэгч сэтгүүлчид өөрийн үйлдэлдээ байнга хяналт тавьж нийгэмд сөрөг нөлөөллийг бий болгохгүйг хичээх нь зүй ёсны хэрэг. Харамсалтай нь өнөөгийн шар сонингуудад өөрсдийн “эрхээ эдэлж буй хүмүүс” бусдын талаар хүссэнээ бичиж байна. Тодруулбал, эмэгтэй улс төрчдийн талаар нийгэмд ямар мессэж хүргэж буй талаар энэ бүтээлд судалсан болно. Сонинуудад гарсан нийт бүтээлийн 50 гаруй хувь сөрөг хандлагатай байгаа нь ямар үр дагавар авчирж болох талаар авч үзэн тодорхой зөвлөмжүүдийг гаргалаа.

ҮНДСЭН ХЭСЭГ

Ардчиллын мөн чанарыг илэрхийлэх нэг үзүүлэлт нь улс төрийн тэгш байдал, нийгмийн төлөөллийг хангахад улс төр дэх эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, оролцоогоор хэмжигддэг. Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтод 2015 он гэхэд үндэсний парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувийг 30-д хүргэхээр тусгасан. Тэгвэл 2012 оны УИХ-ын гишүүний сонгуулиар квот тогтоосны дагуу 11 эмэгтэй гишүүн сонгогдож, парламент дахь эмэгтэй гишүүдийн эзлэх хувийг 15 хувь болгосон юм. Энэ нь өнгөрсөн сонгуулийн дүн (2008 онд 4 хувь)-ээс дээр үзүүлэлт боловч 30 хувийн зорилтонд хүрэхэд нэмэлт арга хэмжээнүүдийг авах шаардлагатайг харуулж байна.

Орчин үед эмэгтэйчүүдийн хүйсийн тэгш байдлыг хангахад олон улсын болон дотоодын байгууллагууд төрөл бүрийн арга хэмжээ авдаг билээ. Сэтгүүлчдийг жендэрийн стереотип буюу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд биеэ яаж авч явдаг тухай хүмүүсийн хоорондын харилцааны явцад үүссэн ерөнхий төсөөллийг бэхжүүлэхгүй байх тал дээр олон улсын улс төрч эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагч байгууллага Interparliamentary Union санаа тавьж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн санаа бодолд төдийгүй нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөгч гол хүчин зүйл. Тиймээс л даяаршлын асуудлыг анх хөндсөн Маршал Маклюэн “олон нийтийн харилцааны хэрэгсэл нь хүний сэтгэхүй, төсөөллийг өргөжүүлэн тэлсэн юм” хэмээх дүгнэлтийг хийсэн биз (Г.Өнөрбаяр “Улс төрийн PR” УБ, 2006, 207 тал). Энэ мэтчилэн сэтгүүлчид эмэгтэйчүүдийн дүр төрх, нийгэм дэх байр суурийг нийгмийн үзэл бодолд үзүүлж буй хүчтэй нөлөөллөөр дамжуулан тодорхойлдог гэж хэлж болно. Ийм учир энэхүү үзэгдлийг анхааралдаа авч, үүнийг улам газар авахаас сэргийлэхийг IPU санал болгож байна. Улс төрийн тавцанд гарах хүнд байдаг учир стереотип нь энэ ажлыг улам хүндрүүлдэг билээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд (ХМХ) улс төр дэх эмэгтэйчүүдийн хувцаслалт, ааш зан зэрэгт анхаарлаа хандуулснаар тэднийг “жижигрүүлж”, хийж бүтээсэн зүйлсийг нь үнэлэхгүй байгаа явдал юм (Learning resource kit for Gender-Ethical Journalism and Media House Policy book 2, 2012).

Эмэгтэйчүүдийн дүр төрх буюу имиж /image/ нь дүр төрх, шинж чанар, нэр төр гэсэн утгатай англи үг юм... Судлаачид имижийг нэр хүнд гэж товчхон тодорхойлдог бол зарим нь “улс төрчийн имиж гэдэг нь олон нийтээс үл хамаарах эсвэл шууд хамаарах ард түмний дундах хошуучлагчийн төсөөллүүд” гэж тайлбарладаг (Г.Өнөрбаяр, Улс төрийн PR, УБ., 2006). Тэгвэл орчин үед Монголын чөлөөт хэвлэлд нийтлэгдэж буй мэдээнүүд эмэгтэйчүүдийн төлөөлөл болсон эмэгтэй улс төрчдийн талаар уншигчид ямар ойлголттой байгааг авч үзье.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож “Сэрүүлэг” сонины 2013 оны 1-20 дугаар, “Ноцтой мэдээ” сонины 2013 оны 10 дугаар, “Хүмүүс” сонины 2013 оны 10 дугаарт нийтлэгдсэн эмэгтэй улс төрчдийн тухай материалыг ашигласан болно. Эдгээр сонин “олон нийтийн” буюу “шар сонин” бөгөөд ард түмэнд хүрч, санаа бодлыг нь тодорхой хэмжээнд төлөвшүүлэхэд хүчтэй нөлөөлдөг билээ. Түүнчлэн жендэрийн стереотипийг сурталчилж, хүчирхэгжүүлэхэд нь нөлөөлөгч хүчин зүйл юм.

“Сэрүүлэг” сонины 2013 оны эхний 20 дугаарын улс төрийн сэдэвтэй мэдээ нийтэлдэг “Парламентын тогоо” буланд 113 мэдээ нийтлэгдснээс 12 нь буюу 11 хувь нь эмэгтэй улс төрчдийн тухай байна. “Хүмүүс” сонинд энэ оны 10 дугаарт 29 мэдээ нийтлэгдсэний зөвхөн 2 мэдээ буюу 6 хувь нь эмэгтэй улс төрчдийн тухай мэдээ байна. Мөн гурван сонины нийгэм, улс төрийн тухай нийт 591 мэдээнээс 39 мэдээ буюу 6 хувь нь л эмэгтэй улс төрчдийн талаар нийтэлсэн байна. Энэ нь 2004 онд хийсэн энэ төрлийн судалгаанаас нэг дахин буурсан асуудал юм (МУИС-НШУС-СЗЭШБ, 237(4), 32 тал). Сэтгүүлчид эмэгтэй улс төрчдийн талаар мэдээлэл өгөхийг татгалзаж, тэдний талаар хэлэлцэхийг эсэргүүцэж байна. Чөлөөт хэвлэлүүд эмэгтэй улс төрчдийн тухай асуудалд төдийлөн ач холбогдол өгдөггүй гэж дүгнэж болох нь.

Эмэгтэй улс төрчдийг тусгасан нийт мэдээ материалын 4,5 хувьд эмэгтэй улс төрчдийг эерэг талаас нь, төвийг сахисан талаас 20,5 хувь, 50,5 хувь нь сөрөг талаас тусгасан бөгөөд эмэгтэйн ерөнхий дүр төрхийг 20,5 хувьд тусгажээ (Хүснэгт № 1). Хэрэв мэдээнд баатрын үйлдэл, үйл ажиллагаа, хэлсэн үг, хийсэн ажил

зэрэгт эерэг үнэлгээ өгсөн, сайшаасан бол эерэг талаас нь тусгасан гэж үзнэ. Ямар нэг үнэлгээ өгөөгүй, цэвэр мэдээллийн шинжтэй бол төвийг сахисан, хэрэв шүүмжлэх, гүтгэх, доромжлох зэргээр дайрч давшилсан бол тухайн улс төрчийн талаар сөрөг имижийг бүтээсэн мэдээ гэж үзсэн. Харин улс төрч бус эмэгтэй хүн гэдэг талаас нь харж, эмэгтэй хүний зан төлөвийг тусгаж, тухайн эмэгтэйн өмссөн зүүсэнд анхаарлаа хандуулсан бол ерөнхий эмэгтэйн дүр төрхийг тусгасан гэж үзлээ. Сөрөг хандлагаас хэдэн жишээ дурдъя: *“Хорооны хөгшчүүлийг “дагздаж” МАХН-ынхнаас кок үнэлгээ авсан З.Баянсэлэнгэ шиг хүүхэн бол “Санагдсанаасаа хэзээд бага ярьж бай” гэх эрх мэдлийн 48 заалтын дөрөвдүгээр дүрмийг олж үзэхгүй явсаар олзны дөрвөн жилээ барах биз”, “Шударгаар дээд албан тушаалд суучихсан нэгэн биш”, “Энгийн хүн бол айсандаа үхэх шахах зүйлийг ичих ч үгүй өгүүлж байсан”, “засаг хатан шиг даналзаж”* гэх мэтээр дорд үзэж, хатуугаар шүүмжилж байгаа нь нийгэмд эмэгтэй улс төрчдийн сөрөг дүр төрхийг бий болгож байна. Судалгаанд хамрагдсан материалд нийт 15 эмэгтэй улс төрч, эрх баригчдын талаар дурдсан байна. Монгол Улсын хүн амын талаас их хувийг (50.5% - 2011, www.nso.mn) эзэлдэг эмэгтэйчүүдийг эдгээр 15 эмэгтэйгээр төлөөлүүлж, тэднийг сөрөгөөр тусгаж байгаа нь харамсалтай юм.

Дээрх судалгаанаас авч үзвэл эмэгтэй улс төрчдийн талаарх нийтлэг дүр төрх ажиглагдаж байна. Үүнд:

- Байнга хэл ам гаргадаг
- Ажлаа хийж чаддаггүй
- Хэлсэн үгэндээ хүрдэггүй
- Болж бүтэхгүй зүйлстэй хутгалддаг
- Ганган хээнцэр, төлөв даруу
- Бусдын хүчээр тухайн албан тушаалд орсон

Эмэгтэй улс төрчдийн талаар нийгэмд сөрөг төсөөлөл бий болсноор тэдэнд итгэх үнэмшил нь буурч, цаашдын үйл ажиллагаанд нь дарамт учруулдаг. Хэрэв сэтгүүлчид үнэхээр улс эх орноо удирдаж буй эмэгтэй улс төрчдийн талаар дээрх дүр төрхийг олон нийтэд бий болгож байгаа бол бид аюулд орсон гэсэн үг. Учир нь

зөвхөн ардчилсан нийгэмд оршин тогтнох боломжтой чөлөөт сэтгүүлзүй эргээд өөрийхөө оршин тогтнох үндсийг үгүй болгож байна. Ардчилсан нийгмийн гол үзүүлэлт болох тэгш эрх, тэгш оролцоо зэргийг дэмжихгүй байгаа явдал нь ардчилсан системийг доголдуулж, өнөөгийн нийгэмд сөрөг нөлөө үзүүлж байна.

Эмэгтэйчүүдийн талаар нийгэмд байгаа сөрөг хандлага, эмэгтэй улс төрчийг туршлагагүй, ажлаа хийж чаддаггүй гэх, эсхүл ялгаварлан гадуурхсан гэх мэт буруу ташаа ойлголтыг засаж залруулахад сэтгүүлчид юу хийх хэрэгтэй вэ? Хүссэн зүйлээ бичиж болно гэсэн үзэлтэй сэтгүүлч олон байдаг. Гэтэл “Сэтгүүлчдийн эрх чөлөө, хүний эрх”-ийн тухай баримт бичгийн долдугаар зарчимд “Жинхэнэ ардчилсан нийгмийн сэтгүүл зүйн практикт мэргэжлийн сэтгүүлчийн ёс зүй гэж бий. Энэ нь д) хүчирхийлэл, үзэн ядах, үл тэвчих үзэл болон арьсны өнгө, хүйс, бэлгийн харилцааны хандлага, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл, үндэс язгуур, нутгийн болон нийгмийн гарлаар ялгаварлан гадуурхах явдлаас зайлсхийх,” гэж тусгажээ. Сэтгүүлчдийн баримтлах зарчмын долдугаар зүйлийн дагуу “Мэдээллийн хэрэгслээр дэвэргэсэн ялгаварлан гадуурхалт ямар аюултайг сэтгүүлч хүн **ухамсарлаж**, улмаар арьсны өнгө, хүйсийн ялгаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн юм уу өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарлаар болон бас бус шалтгаанаар ялгаж гадуурхахаас сэрэмжлэхийн төлөө чадах бүхнийг хийх” гэсэн нь маш чухал юм. Хамгийн гол нь сэтгүүлч өөрийн үйл ажиллагаа ямар их нөлөөтэй, үр дагавартайг ухамсарлаж, цаашдын ажилдаа болгоомжтой, няхуур хандах явдал билээ.

Гадаадын туршлагаас авч үзье. Хэвлэлийн эрх чөлөө, иргэдийн улс төр дэх оролцоогоороо жагсаалтыг тэргүүлдэг Скандинавын орнууд, тэр дундаа Швед Улс эмэгтэй улс төрчдийн парламентад эзлэх хувиараа мөн л дэлхийн 180 гаруй орноос жагсаалтын хамгийн дээгүүрт бичигддэг. Швед 1766 онд хэвлэлийн эрх чөлөөг үндсэн хуулиндаа хангасан хамгийн анхны орон болжээ. Хэвлэлийн эрх чөлөөг дээдэлсэн энэ оронд өөрсдийгөө хянах систем хэрэгждэг бөгөөд иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хэрэглэсний татвар төлдөг учир иргэдийн хяналтын систем ч хүчтэй ажилладаг. Хэрэв иргэн сонинд бичигдсэн нийтлэл ёс зүйг зөрчсөн гэж үзвэл хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэгдлүүд, бүгд харилцан

тохиролцоонд хүрсэн үндсэн дээр ёс зүйн хэм хэмжээг сахиж, “шүүх” арга хэмжээ явуулдаг байна. Буруу нь тогтоогдсон тохиолдолд тухайн ХМХ хариуцлага хүлээдэг. Түүнчлэн жил бүр “Хамгийн ёс зүйтэй” ХМХ-үүдийн жагсаалт гардаг юм. Ингэснээр мэдээлэл хүлээн авагчид өөрсдийн сонголтоо хийх боломжтой юм. Мөн бас нэгэн нөлөөлөгч хүчин зүйл бол боловсролын систем юм. Скандинавын орнуудын дээд боловсрол үнэ төлбөргүй олгогддоггоос гадна чанартай байдаг. Зөвхөн “элит”-үүд болон боломжийн айлын хүүхдүүд сэтгүүлч болдог гэсэн ойлголтыг авч хаяж, эрхийг дээдэлсэн, олон ялгаат байдлыг хадгалдаг юм.

ДҮГНЭЛТ

1. Чөлөөт хэвлэлд эмэгтэйчүүдийн талаар мэдээлэл дамжуулахдаа буруутгах, “жижигрүүлэх” хандлага ажиглагдаж байна
2. Улс төрч эмэгтэйчүүдийн талаар нийгэмд сөрөг дүр төрх үүсгэснээр улс төрч эмэгтэйчүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг бөгөөд цаашид улс төрийн тавцанд гарах, ажиллах хүсэл сонирхлыг унагаадаг
3. Чөлөөт хэвлэлүүд жендэрийн стереотипийг хүчирхэгжүүлснээр эргээд “чөлөөт хэвлэл”-ийн оршин тогтнох үндсийг үгүй болгож байна
4. Хүйсийн ялгаагаар ялгаварлан гадуурхах нь ёс зүйн ноцтой зөрчил юм
5. Сэтгүүлчид өөрсдийн ёс зүйн үүргийг ухамсарлаж, хариуцлагатай хандах

Дээрх дүгнэлтээс үндэслэн сэтгүүлчийн үйл ажиллагаанд анхаарал тавибал зохих зүйлсийн талаар болон авах боломжтой арга хэмжээний тухай ЗӨВЛӨМЖ гаргаж байна.

- Мэргэжлийн ёс зүйн зарчмыг шинэчилж, баримтлах арга хэмжээнүүдийг авах
- Хяналтын тогтолцоог бий болгох – ХМХ-үүд өөрсдийгөө хянадаг байх, Уншигчид өөрсдийн үзэл бодлоо редакцтай хуваалцаж байх
- Ёс зүйн хэм хэмжээг мөрдөх талаар сэтгүүлчдэд зориулсан гарын авлагатай болох

- Ялгаварлан гадуурхалтын талаар тодорхой стандарттай болж, цаашид тууштай мөрдөх
- “ХМХ дэх ёс зүй” – Монголын ХМХ-үүдийг ёс зүйгээ баримталж буй байдлаар жагсаах
- Эмэгтэй улс төрчдийн оролцоо нь ардчиллын чухал үзүүлэлт гэдгийг ухамсарлаж бичиг үсгийн алдаагаа шалгадаг шиг жендэртэй холбоотой үг хэллэгээ хянаж, үгийн сонголтондоо дээд зэргээр анхаарч байх
- ХМХ-үүд ялгаварлан гадуурхлын асуудалд мэдрэмжтэй ханддаг сэтгүүлчдийг ажилд авах. Ингэснээр бусад сэтгүүлчид энэ асуудалд өөрийн ур чадвар, мэдлэг боловсролыг нэмэгдүүлж, цаашид ялгаварладаггүй болох

Хүснэгт №1

Улс төрч эмэгтэйчүүдийн имижийг тогтмол хэвлэлд гаргасан байдал

	Нэр	Албан тушаал	Эерэг		Төв		Сөрөг		Ерөнхий		Нийт тоо
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
1	Б.Оюунчимэг	МАН-ын УЗГ							1	100	1
2	Д.Алтай	Хүүхдийн төлөөх газрын дарга					1	100			1
3	Ц.Оюунгэрэл	УИХ-ын гишүүн, ССАЖ-ын Сайд			1	20	3	60	1	20	5
4	Д.Арвин	УИХ-ын гишүүн	2	34			3	50	1	16	6
5	Д.Цэрэнчимэг	Дорнод аймгийн АН Дарга					2	100			2
6	Ц.Оюундарь	АН-ын Генсекийн үүрэг гүйцэтгэгч			1	100					1
7	З.Баянсэлэнгэ	УИХ-ын гишүүн			1	14	6	86			7
8	Г.Уянга	УИХ-ын гишүүн			1	33	1	33	1	33	3
9	Д.Туяа	УИХ-ын гишүүн асан					1	100			1
10	Д.Баярсайхан	МАН-ын хорооны хэрэг эрхлэх газрын дарга			1	100					1
11	Э.Оюунхорол	УИХ-ын гишүүн							1	100	1
12	С.Оюун	УИХ-ын гишүүн, БОНХ-ийн Сайд			1	20	2	40	2	40	5
13	С.Одонтуяа	УИХ-ын гишүүн					2	100			2
14	Н.Удвал	УИХ-ын гишүүн, ЭМ-ийн Сайд			3	42	3	42	1	14	7
15	Ш.Солонго	ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын тэргүүн							1	100	1
		НИЙТ	2	4.5	9	20.5	24	54.5	9	20.5	44

Улс төрч эмэгтэйчүүдийн имижийг тогтмол хэвлэлүүд үгээр илэрхийлсэн байдал

	Нэр	Имижийг үгээр илэрхийлсэн байдал
1	Б.Оюунчимэг	Ерөнхий: <ul style="list-style-type: none"> • <i>Наагуур цаагуур шулганан гүйж, тусгаар тогтнолын ордны жаврыг үргээж буй цөөн эмэгтэйчүүдийн нэг (С2013:2)</i>
2	Д.Алтай	Сөрөг: <ul style="list-style-type: none"> • <i>Өдийг хүртэл тамгаа авч зугтаагаад албан тушаалтайгаа зууралдсаар</i> • <i>Шударгаар дээрх албан тушаалд суучихсан нэгэн биш</i> • <i>Үхэн хатан зугтааж байгаа (С2013:2)</i>
3	Ц.Оюунгэрэл	Ерөнхий: <ul style="list-style-type: none"> • <i>Парламентын мисс, титэмгүй болохоос мисс</i> • <i>худлаа үнэн хэлж, хэлсэн үгэндээ ороогддог хүүхнүүдээс тэс өөр</i> • <i>намынхаа эмэгтэйчүүдийг удирдаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвлөж явсан энэ улс төрч эмэгтэйг муу хэлэх хүн ховор (С2013:5)</i> Төв: <ul style="list-style-type: none"> • <i>Баярын өдрөөр ч ажил хэрэгч имижээ орхиж чадсангүй (С2013:9)</i> Сөрөг: <ul style="list-style-type: none"> • <i>Тэгээд ч манай сайд гадаад нөхөртэй болохоор үндэсний урлагаа ойлгодоггүй бас ойшоодоггүй биз, драмын театрынхан шинэ оркестртой болоод тоглолт хийхэд очиж үзсэн дээ (С2013:10)</i> • <i>Соёл, спорт, аялал, жуулчлал хэмээх асар том салбарыг хариуцдаг атал яамныхаа ажлыг нэг зүйл рүү л зүтгүүлээд байгаа гэнэ (С2013:14)</i> • <i>Урлагийн хэддээ ялгавартай ханддаг гэсэн ярианы эзэн болжээ</i> • <i>Т-Батаарын араас хөөцөлдөж үндсэн ажлаа мартаж шахуу болсон</i> • <i>Хэрвээ том алдартай жүжигчнийг тоглуулахгүй л бол яам тоохгүй янзтай (С2013:20)</i>
4	Д.Арвин	Эерэг: <ul style="list-style-type: none"> • <i>Ардчилсан нам руу урвасан биш тус намд сүрхий эрх мэдэлтэй хүн болж хувираад байгаа бөгөөд түүнийг АН-ын фракциуд булаацалдаад сүйд болж байгаа юм байх аа (НМ2013:2)</i> • <i>түүний сайхан сэтгэл, хийж бүтээх гэсэн эрмэлзлэлийг нь баянзүрхчүүд баллаад байгаа (С2013:7)</i>

		<p>Ерөнхий:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Арав гаруй жил мяраалаг төрхөөр имижээ хийж явсан Д.Арвин гишүүн огцом турж, миссүүдийн эгнээнд шилжлээ (С2013:15)</i> <p>Сөрөг:</p> <ul style="list-style-type: none"> • <i>“гэнэт шарваж”, “атаман зантай”, “зүдэрч яваа”</i> • <i>Дуугүйхэн гутлын хониоороо ширтэн доогуур харан алхаж</i> • <i>Сэм сэмхэн эвшээн суух болжээ (С2013:2)</i> • <i>хор нь хөдлөөд АН-д орчихсон</i> • <i>хүслийг нь биелүүлэх байтугай уулзахгүй зугтаж сураг тасарчээ (С2013:7)</i> • <i>“Алтыг нь аваад авдрыг нь хаяхын үлгэр боллоо”</i> • <i>Зам зуураас нь заль мэх хэрэглэн орж ирснээс замхарч, одоо болтол эмнэлгийн барилга баригдаагүй байгаа ажээ</i> • <i>Эмнэлэгт зориулсан мөнгийг нохойн замаар оруулсан (НМ2013:3)</i> • <i>Морь сэтэрлэн тавих, орд өргөө барих зэргээр цаг заваа гарздаж явдаг нэгэн юм</i> • <i>Энгийн хүн бол айсандаа үхэж ч мэдэхээр эвгүй юмыг ичих ч үгүй өгүүлж байсан</i> • <i>Түүнд яах аргагүй Дондогдулам хатны сүнс шүглэжээ. Хэрэв үгүй бол түүний сэтгэцийн байдал сэжигтэй болсон байна. Энэ хоёрын аль нь ч болсон бай хоёулаа л аюултай учраас юуны өмнө Баянзүрх дүүргийнхэн ахин сонгууль хийж магадгүй хэмээн сэтгэл зүйн бэлтгэл базааж байхад илүүдэхгүй юм (НМ2013:6)</i>
5	Д.Цэрэнчимэг	<p>Сөрөг:</p> <ul style="list-style-type: none"> • <i>“бас л уйлж унжих шахуу юм болж”</i> • <i>“засаг хатан шиг даналзаж” (С2013:3)</i> • <i>Ерөнхий сайдын өрөөнөөс гарч ирэнгүүтээ баярласан хэрээ бархирна гэгч болж, тал тал тийшээ утас цохин “Би Ерөнхий Сайдтай сая яриад тохирчихлоо. Жанлав гуайг Засаг Дарга болгоод би доор нь орно” гэж ярьж гарчээ (С2013:18)</i>
6	Ц.Оюундарь	<p>Төв:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Намын зарим нөхөд нь “соёлтой шахаа” хэмээн эсэргүүцсэн</i> • <i>Хэл ам гаргагчдыг мохоожээ (С2013:3)</i>
7	З.Баянсэлэнгэ	<p>Төв:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Бухимдсан гишүүн, албан тушаалтан хоёр ямар нэг удирдамж, захирамжгүйгээр дээрх газрын [Хүүхэд асрах “Өгөөмөр” төв] зөвшөөрлийг нь хураан авсан аж</i> • <i>Түүний дэгдээсэн энэхүү асуудлыг удахгүй УИХ-ын Ёсзүйн байнгын хорооны хуралдаанаар авч хэлэлцэх юм (Х2013:10)</i> <p>Сөрөг:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Гудамжны улс төрч</i> • <i>Харамсалтай нь эрхэм гишүүн биеэ барьж чаддаггүй нэгэн</i>

		<p><i>болтой(С2013:5)</i></p> <ul style="list-style-type: none"> • Улс төрийг гэр бүлийн гишүүдийн орж гарч байдаг хувийн байгууллага мэт ашигладаг улс төрчид манай ЗГ, УИХ-ын тоонд цөөнгүй бий...Хамгийн сүүлд УИХГ З.Баянсэлэнгэ нөхрөө хорооны ЗД болгох гэж улайран тэмцэж яваа • Албан тушаалын амтанд орно гэдэг энэ байх (С2013:6) • УИХ-ын гишүүн болсон цагаасаа бодолгүй хэлсэн үгэндээ ороогдон, будилах нь хэрээс хэтэрлээ • Хорооны хөгигчүүлийг “дагздаж” МАХН-ынхнаас кок үнэлгээ авсан З.Баянсэлэнгэ шиг хүүхэн бол “Санагдсанаасаа хэзээд бага ярьж бай” гэх эрх мэдлийн 48 заалтын дөрөвдүгээр дүрмийг олж үзэхгүй явсаар олзны дөрвөн жилээ барах биз (С2013:7) • Баахан иргэд цуглуулж, байдгаараа хашигирч • Улс төрлүү орсон шалтгаан тун энгийн байсан хэд хоног өлсгөлөн зарлаж, жигсаал хийснийх нь хөлсөнд нам нь түүнд УИХ-ын гишүүн гэх албан тушаалын амтыг мэдрүүлсэн (С2013:14) • Нүдэндээ давхраа оёулж (С2013:15) • Харин Н.Энхбаярын төлөө жагсаал цуглаан болгон дээр ирж, бие нь муудлаа гэхэд гэрлийн хурдаар идэг үнэнч фен УИХ-ын гишүүн З.Баянсэлэнгэ нь үүнийг эрс няцааж байна • Ийнхүү улайм цайм худлаа хэлсэн нь МАХН-ын дотоод дахь зөрчлийг улам тод харуулж байгаа хэрэг юм (Х2013:20)
8	Г.Уянга	<p>Ерөнхий:</p> <ul style="list-style-type: none"> • Амлалт нэхэх ард түмний холбооны тэргүүн Г.Уянгад УИХ-ын гишүүний сэнтий зохиж байна гэдэг нь ванлий. Уруул, амны хөдөлгөөн, ярьж хэлж буй зүйлийн утга учир, дэвшүүлж буй санаа оноо нь хэдэн жил улс төрийн тогоонд мэтгэлцэж, хэрүүл зарга хийх үедээ хийж явсных нь үр дагавар биз ээ. Мань хүний стивь, имиж хүртэл цаанаа нэг нийцтэй. Бүр сүүлдээ Тимошенко үстэй болчихсон тууж явах. (С2013:7) <p>Төв:</p> <ul style="list-style-type: none"> • Г.Уянга гишүүн С.Баярцогт гишүүн[ий] асуудлаар Ерөнхийлөгчид хүртэл хандах нь (Х2013:16) <p>Сөрөг:</p> <ul style="list-style-type: none"> • Бараг л ногоон гэрлээр төрийн шаргал ордонд залсан • Нүдэн балай чихэн дүлий болсон нэгэн (С2013:10)
9	Д.Туяа	<p>Сөрөг:</p> <ul style="list-style-type: none"> • Тэрбумтан эмэгтэйн гэрээс мөнгө хулгайлсан этгээд өөрөөс нь дүү “найз залуу” нь байсан тухай үнэн худал нь үл мэдэгдэх шивнээ яриа газар авсаар байна. (С2013:7)
10	Д.Баярсайхан	<p>Төв:</p> <ul style="list-style-type: none"> • УИХ-ын болон орон нутгийн сонгуульд дараалан ялагдсан тул арга буюу намын хорооны даргын ажлаа өгсөн (С2013:7)

11	Э.Оюунхорол	<p>Ерөнхий:</p> <ul style="list-style-type: none"> Цэцгэн хээтэй даашинз өмссөн (С2013:9)
12	С.Оюун	<p>Ерөнхий:</p> <ul style="list-style-type: none"> Шударга, элдэв ад шуналгүй, энгийн сайхан бүсгүй Нүүр нүдээ буддаггүй, элдэв өсгийтэй гутал, тоногтой хувцас өмсдөггүй төв даруухан эмэгтэй Хувцсаа өдрийн хэд сольж нэг өмссөн хувцсаа дахиж өмсөхгүй гэдэг хүүхнүүд С.Оюун гишүүнээс үлгэр аваасай (С2013:10) Төлөв даруу, хар цагаан өнгийн хослол өмсжээ (С2013:9) Ногоон хөгжлийн бодлого нь Монгол Улсын тулгуур бодлого байх болно гэдгийг БОНХ-ийн сайд С.Оюун уулзалтын эхэнд хэлээ (Х2013:19) <p>Сөрөг:</p> <ul style="list-style-type: none"> Ж.Занаа “Оюун бүүр хэрэггүй. Лидер биш...Маш хариуцлагагүй эмэгтэй” (С2013:14) Илэрхий байгаль эхтэй шөргөөцөлдсөн балай ажил санаачилсан байна Яах аргагүй дундаас нь мөнгө тоншсон хэрэг болж таарч байгаа юм (НМ2013:8)
13	С.Одонтуяа	<p>Ерөнхий:</p> <ul style="list-style-type: none"> Сувдаар гангардаг энэ тэр гэсэн мэдээ “шидүүлж”, тэрүүхэндээ эмэгтэйлэг зангаа илэрхийлж байдаг (С2013:15) Сайд С.Эрдэнийг бараадсаар байгаад улс төрд орж УИХГ болоод амжсан Улаа бутартал уусан зураг олонд гарчээ УИХ-д орж ирээд “унтарч”, жинтэй үг хэлж чадахгүй, твиттерээр нэг л их жиргэсэн завтай эмэгтэй болон хувирсан (С2013:16)
14	Н.Удвал	<p>Төв:</p> <ul style="list-style-type: none"> МАХН-ын сайд нараас барцад салахгүй нь (С2013:1) Бичиг баримт дутуу мөн зарим нэг зүйл нь бүрхэг байгаа ч онцын шаардлагагүй нөхөж өгнө гэдэг шалтгаанаар бүртгэсэн гэнэ Аргагүй азтай хүн Чин сэтгэлээ дагаж хэзээ нэгэн цагт шагнал ирдэг болохоор одоо Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших мандаа өвөртөлчихсөн явна (С2013:20) Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Монголын түүхэнд анх удаа эмэгтэй хүн нэр дэвшин өрсөлдөж байна (НМ2013:17) Н.Удвал “Торгоны замыг сэргээнэ” гэж хариулсан нь ихээхэн анхаарал татсан (НМ2013:18) <p>Сөрөг:</p> <ul style="list-style-type: none"> Жижиг ч гэсэн хууль зөрчсөн үйлдэл (С2013:19) Чухамдаа Н.Удвалын ард Н.Энхбаяр байгаа гэсэн том фон л

		<p><i>Н.Удвалыг өндөрт өргө[nө]</i></p> <ul style="list-style-type: none"> • <i>МАН-ын дэмжигчид тэгэхээс тэгэх гэж Н.Удвалд санал өгвөл ийм л юм болно (НМ2013:16)</i> • <i>Даргынхаа шийдвэрийг үл тоомсорлон гарч ирсэн болохоор санал өгөлгүй унагах хандлага бий (Х2013:20)</i> <p>Ерөнхий:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Н.Удвал бол хүүхэд эх барьж авах, халбага сэрээ цуглуулах, даргын нарийн бичиг хийх зэргээр жинхэнэ эмэгтэй хүний хийдэг ажилтай зууралдаж явсаар өдийг хүрсэн нэгэн юм</i>
15	Ш.Солонго	<p>Ерөнхий:</p> <ul style="list-style-type: none"> • <i>Төрд нухлагдсан хатагтай</i> • <i>16 сая төгрөг авсан ч буцаан өгсөн гэсэн (С2013:19)</i>

АШИГЛАСАН НОМ, ЗОХИОЛ

- МУИС-НШУС-СЗЭШБ, 237(4), 32 тал
- Г.Өнөрбаяр “Улс төрийн PR” УБ, 2006, 207 тал
- Learning resource kit for Gender-Ethical Journalism and Media House Policy book 2, 2012
- The Status of Women in the US Media 2014, Women’s Media Center, USA, 2014

Веб хүүдас

- www.guardian.com
- www.ipu.org
- www.globeinter.mn